

АРХИНЫ ХАМААРАЛТАЙ, ГЭР ОРОНГҮЙ, ТЭНЭМЭЛ АМЬДРАЛТАЙ ИРГЭДИЙН НӨХЦӨЛ БАЙДЛЫГ СУДАЛСАН НЬ

*Л. Баянмөнх
Докторант*

*Шинжлэх ухаан, технологийн их сургууль
Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургууль*

babuk2016@yahoo.com

***Хураангуй:** Австралийн эрдэмтэн Рожер Ван Дер Вийний нөхцөл байдлын үнэлгээний загвараар архины хамааралтай, гэр оронгүй, тэнэмэл амьдралтай 15 иргэний нөхцөл байдлыг судаллаа. Архины хамааралтай, гэр оронгүй, тэнэмэл амьдралтай иргэдийн талаарх нийгмийн тогтсон хандлага буруу болохыг энэхүү судалгааны үр дүн харууллаа. Түүнчлэн тэдний итгэл үнэмшлийн загварыг өөрчилж чадвал архинаас гарч, дахин нийгэмшиж, гэр бүлдээ эргэн нэгдэн, нийгмийн амьдралд идэвхтэй иргэн болох боломжтой ажээ.*

***Түлхүүр үгс:** Архинд донтох өвчин, тэнэмэл амьдралтай иргэн, нөхцөл байдлын үнэлгээ, зан үйл*

УДИРТГАЛ ХЭСЭГ

Манай улс зах зээлийн нийгэмд шилжин хөгжиж байгаа хэдий ч баян, ядуугийн ялгаа нэмэгдсээр байна. Ядуурлын түвшинд нөлөөлж байгаа нэг хүчин зүйл нь архины хамааралтай, гэр оронгүй иргэдийн асуудал юм. 2016 онд Үндэсний статистикийн хороо, Дэлхийн банк хамтран хийсэн “Ядуурлын дүр төрх – 2016” судалгаагаар МУ-ын хүн амын 29,6% буюу 907,5 мянган хүн ядуу байна.¹⁸ 2015 онд хийсэн Хүн ам, орон сууцны завсрын тооллогоор улсын хэмжээнд 890 гэр оронгүй

иргэнийг бүртгэжээ.¹⁹ Гэр оронгүй хүмүүс нь гэмт хэрэг үйлдэх, гэмт хэргийн золиос болох, нийгмийн хэв журам зөрчих, согтууруулах ундаа байнга хэтрүүлэн хэрэглэх, бэртэх гэмтэх, траншейны халуун усанд түлэгдэх, осгож хөлдөх, гар хөлөө тайруулах, өвчин тусах, хонох газар олдохгүй тэнүүчлэх, хоол унд хомс байх, сэтгэл санаагаар гутрах цөхрөх зэрэг нөхцөл байдлуудтай тулгаран зовж шаналж байдаг. Түүнчлэн олонх нь архинд орж, амьдралд болон өөртөө итгэх итгэлгүй болсон байдаг. Бохир, муухай үнэртэй, ихэнхдээ согтуу байдаг учраас тэдний талаарх хүмүүсийн сөрөг бодол, хандлага нь тэднийг нийгмээс

¹⁸ Үндэсний статистикийн хороо, Дэлхийн банк “Ядуурлын дүр төрх-2016” судалгаа

¹⁹ МУ-ын Үндэсний статистикийн хороо, 2015

тусгаарлагдаж, гадуурхагдах шалтгаан болдог. Манай оронд үүсч бий болсон нэн даруй шийдвэрлэвэл зохих асуудлын нэг болоод байгаа “траншейныхан”, “өвгөнтийнхөн” гэгдэх эдгээр иргэдийг дахин нийгэмшүүлэхэд, мөн энэ чиглэлээр ажилладаг мэргэжилтэн, судлаачдад энэхүү дэлгэрэнгүй нөхцөл байдлын үнэлгээний үр дүн суурь мэдээлэл болно.

ОНОЛ, АРГА ЗҮЙН ХЭСЭГ

Архинд донтох өвчин нь өвчний олон улсын 10-р ангиллын дагуу F10 гэсэн оношийн шалгуураар оношлогддог сэтгэц зан үйлийн эмгэг юм. Архи, спиртийн төрлийн ундаа нь хүний уураг тархи, сэтгэцийг мансууруулах үйлчилгээтэй донтуулагч бүтээгдэхүүн бөгөөд эмх замбараагүй удаан хугацаагаар хэрэглээд байвал архийг хэрэглэхгүйгээр байж чадахгүй байдалд хүрэх буюу архины хараат байдалд ордог. Ингэж архины хараат байдалд орохыг архинд донтох эмгэг гэж нэрлэдэг. ДЭМБ-тай хамтран 2005 онд Монгол улс дахь хүн амын архины хэрэглээний хортой үр дагаварыг судлах судалгаагаар 10000 хүн амд 13.6% нь архинд донтох өвчтэй болох нь тогтоогдсон. Монгол улсад архинд донтох өвчин сүүлийн 10 жилд 2

дахин өссөн бөгөөд архины хэрэглээ нь Европын орнуудаас 2 дахин их байна.²⁰

Архинд донтох өвчин ихсэх үү эсвэл багасах уу гэдэгт аливаа улс орны төр, засгийн бодлого онцгой үүрэгтэй гэж сүүлийн үед судлаачид их бичиж байна. Архинд донтох өвчин үүсэн бий болоход бие хүний нийгэмд эзлэх байр суурь, түүнд хамт олны зүгээс хандах хандлага тодорхой нөлөө үзүүлж байна. Харилцан бие биенээ дэмжин хамтран уудаг нөхдийн дундаас архинд донтох өвчтөн төрдөг жамтай аж.²¹ Нийгмийн хүчин зүйлсийн нэг бол архийг байнга хэтрүүлэн хэрэглэдэг нэг буюу хэд хэдэн хүний сөрөг нөлөөнд архийг хэтрүүлэн хэрэглэх дуртай хүмүүс автах явдал гэж судлаачид үздэг. Сэтгэл зүйн хүчин зүйлд мэдрэл сэтгэцийн тогтолцооны сул, тэнцвэргүй хэв шинжтэй, нийгэм хамт олонтой дасан зохицох чадвар султай бие хүн архинд амархан автаж байна гэж профессор С.Бямбасүрэн бичжээ. Удам зүйн үзлээр архидан согтуурдаг гэр бүлд төрсөн хүүхэд эрүүл хүмүүсийн хүүдүүдийг бодвол архичин болох нь элбэг. Архинд донтох өвчтэй 4372 хүнийг шинжлэхэд 52% нь тэдгээрийн эцэг эх архинд донтох өвчнөөр өвдөж байсан байна. Гэхдээ архинд донтох өвчин удамшдаг гэж шууд

²⁰ “Архины хамааралтай хүмүүсийн ялгаварлан гадуурхах, муу нэрийн шошго зүүх үзэгдлийг судалсан нь” Монголын

анагаахын сэтгүүлүүдийн холбоо 2015, 15 (9-1)

²¹ Эрдэнэбаяр.Л., Архинд донтох өвчин., УБ., 2009

тогтоогоогүй. Харин архинд донтох өвчин үүсэхэд нөлөөлөгч сэтгэл зүйн болон биологийн онцлогууд удамшдаг байна. Одоогоор шинжлэх ухаанд архинд донтох өвчний шалтгааныг тайлбарласан нэгдмэл үзэл гараагүй байна. Архинд донтсон хүний зан үйлийг өөрчлөхөд туслах 2 үндсэн арга зам байна.

1. Хувь хүний итгэл үнэмшилд тулгуурлан хэвийн бус зан үйлийг нь өөрчилж эерэг зан үйлийг төлөвшүүлэх

2. Зан үйлээ өөрчлөхөд дэмжлэг үзүүлэх таатай орчин бүрдүүлэх замаар эерэг зан үйлийг төлөвшүүлэх.

Эрүүл болохын тулд зан үйлээ өөрчилж буй хүмүүст дараах дарааллаар дэмжлэг үзүүлнэ. Аль нэг заалтыг тухайн хүн шаардлагагүй гэж үзвэл орхиж болно.

1. Хувь хүн өөрийнхөө эрүүл мэндийн тухай бодит мэдээлэлтэй болох

2. Өөрийн эрүүл мэндийн бодит мэдээлэл рүү анхаарлаа хандуулах

3. Эрүүл мэндийн тухай мэдээлэл нь тухайн хүний итгэл үнэмшилтэй хэрхэн тохирох талаар харьцуулалт хийх

4. Урьд өмнө өөрт байсан бодол санаагаа өөрчлөх

5. Өөрт нь шинээр бий болж буй бодол санаа итгэл үнэмшлийг бататгах

6. Өөрийгөө удирдах шинэ чадварыг эзэмшүүлэх

7. Эрүүл зан үйлийг хэвшүүлэх оролдлого хийх

8. Шинэ зан үйлийг өөрт хэвшүүлж дадал болгох

Хэрэв зан үйлээ өөрчилье гэвэл дээрх шат дараалсан бүх үйл ажиллагаануудыг амжилттай хэрэгжүүлэх хэрэгтэй. Тухайн хүний итгэл үнэмшлийг өөрчлөхгүйгээр зан үйлийг нь өөрчилнө гэдэг бол тийм ч бодитой зүйл биш. Зан үйлийг өөрчлөх үе шатуудыг хэрэгжүүлэхэд цаг хугацаа, нэлээд бэрхшээлтэй олон асуудлууд тулгардаг.

Өөрчлөлтийн үе шатны онол

Зан үйлийг өөрчлөх гэдэг нь цаг хугацаа шаардсан, хэд хэдэн үе шатыг дамждаг үйл явц юм. “Өөрчлөлт хийх үе шат”-уудын загварын талаар энд өгүүлье.

1. Ухаарлын өмнөх үе шат. Архинд донтсон гэдгээ асуудал гэж боддоггүй үе.

2. Ухаарлын үе шат. Хүн өөртөө аажмаар өөрчлөлт хийх талаар бодож эхэлдэг.

3. Бэлтгэл үе шат. Өөрчлөлт хийх талаар мэдээлэл цуглуулах, өөрчлөлт хийхийг эрэлхийлэх, ямар чадвар эзэмшсэн байх талаар суралцах, хэзээ өөрчлөлтийг хийх талаар шийдвэр гаргах зэрэг бэлтгэлийг хангана. Өөрчлөлт хийснээр ямар үр дүнд хүрэх, хэнд илүү ашигтай талаар ярилцах нь ашигтай.

4. Үйл ажиллагаа болгох үе шат. Урьд нь гаргасан шийдвэр, туршлага, мэдээлэл, шинээр эзэмшсэн чадварууд, бусдын

урамшуулал дэмжлэгүүдэд үндэслэн зан үйлээ өөрчлөх үйлдлээ ажил хэрэг болгоно.

5. Зорилгодоо хүрэх үе шат. Нэгэнт зан үйлийг бий болгосон тохиолдолд түүнийгээ тогтмол хэвшүүлэх хэрэг гардаг. Энэхүү шинээр олж авсан зан үйлээ амьдралынхаа туршид хэвшүүлж чадсан үед л зорилгодоо хүрлээ гэж үздэг.

Өөрчлөлтийг хийхэд эхлээд хялбар мэт боловч шинэ зан үйлийг хэвшүүлэх нь амаргүй. Өөртөө хатуу шаардлага, зорилго тавьсан хүн л шинэ зан үйлээ хэвшүүлж чадна.

Хүмүүс зан үйлийн өөрчлөлтийн үе шатуудаар дамжин явахад нэгэн ижил үйл явцууд давтагддаг учраас зарим үйл явц нь нэг ба түүнээс дээш тохиолдож болно.

Донтох зан үйл бол биологи-сэтгэл зүй-нийгмийн үзэгдэл бөгөөд архинд донтох зан үйлийг дараах онолуудаар тайлбарладаг. Үүнд: Зан үйлийн онол, Психоаналитик онол, Нийгмээс суралцахуйн онол, Нөхцөлт рефлексийн онол, Гэр бүлийн системийн онол, Нийгэм-соёлын онол, Генетикийн онол, Нейробиологийн онол, Нийгэм-улс төрийн онол, Ёс суртахууны онол зэрэг болно.²²

Зан үйлийн онол

Хувь хүний түвшинд ч бай, олон нийтийн түвшинд ч бай, эерэг зан үйлийг төлөвшүүлэх, сөрөг зан үйлийг өөрчлөх нь маш хэцүү зорилт гэдэгтэй мэргэжилтнүүд санал нэгддэг. Гэхдээ үүнийг амжилттай хэрэгжүүлж чадсан тохиолдолд үр дүн нь урт удаан хугацаанд ашиг тусаа өгсөөр байдаг гэдэг нь батлагджээ.²³

Архины хамааралтай, гэр оронгүй, тэнэмэл иргэдийг дахин нийгэмшүүлэх үйл явцыг эрүүл мэндийн зан үйлийн онолуудаар тайлбарлаж болно. Эрүүл мэндэд нөлөөтэй гурван янзын зан үйл байдаг бөгөөд тэдгээр нь тус бүр өөр өөр үйлдэл хийх сэдэл төрүүлдэг болохыг судалгаагаар тогтоосон байна.

1. Урьдчилан сэргийлэх зан үйл- өвчлөхгүйн тулд хийж буй үйлдэл

2. Өвчний зан үйл- ямар нэг өвчний шинж тэмдэг илэрч байгааг мэдсэн үедээ хүний хийж буй хариу үйлдэл.

3. Өвчтэй үеийн зан үйл- тухайн хүн өвчтэй гэдгээ оношлуулсан үедээ хийж буй үйлдэл.

Хүүхэд өсвөр үеийнхний хувьд зан үйлийг төлөвшүүлэн хөгжүүлэхэд хөтөлбөрийн үйл ажиллагаа голлон чиглэдэг бол насанд хүрэгчидтэй ажиллахад зан

²² Хорт зуршил ба нийгмийн ажлын үйлчилгээ, Нийгмийн ажлын зуны сургалт 2007

²³ Нейл МакКни нар Зан үйлийн төлөвшил ба хүмүүсийн оролцоо., УБ., 2008

үйлийн өөрчлөлт болон өөрчлөгдсөн зан үйлийг хэвшүүлэх тал дээр голлон анхаардаг. Зан үйлийн өөрчлөлтийн хөтөлбөрт оролцогч нэгэн “Тиймээ, зан үйлээ өөрчилж болно. Гэхдээ ингэхийн тулд надад тодорхой шалтгаан байх хэрэгтэй... Намайг зан үйлээ өөрчлөхөөс өмнөх нөхцөл байдал өөрчлөгдсөн байх шаардлагатай... Надад хүсэл эрмэлзэл байх хэрэгтэй, шинэ сэдэл, ямар нэг шинэ өөр зүйл бий болж, өөрчлөгдөн сайжирсан байх хэрэгтэй... эсвэл аливаа зүйлийг цоо шинээр харж, шинэ өвөрмөц маягаар хүлээж авах ёстой. Яагаад, яаж, хаана гэх мэтээр аливаа зүйлийг шинэ маягаар хийхэд хувь хүнийг уриалан татан оролцуулж байж л энэ өөрчлөлт бий болно. Зан үйлээ өөрчилснөөр эдийн засгийн хувьд ч юмуу ямар ашиг тус гарах нь тодорхой байх хэрэгтэй... Шинэ зан үйл ямар ашиг тустайг би ухаарсан байх шаардлагатай... Миний нөхцөл байдлыг өөрчилж чадаж байвал л сонирхлыг маань татаж чадна... Миний амьдрал тохирсон, нийцсэн байх ёстой.” гэжээ. Энэхүү хүсэлт, шаардлагууд нь аливаа хүний зан үйлийг өөрчлөх хөтөлбөрийн зайлшгүй бүрэлдэхүүн хэсгүүд мөн.

Нийгмээс суралцахуйн онол
1986 онд Альберт Бандурагийн боловсруулсан Нийгмээс суралцахуйн онол нь хувь хүмүүс нийгмийн орчинтойгоо

(найз нөхөд, гэр бүл, ажлын хамт олон г.м) тогтмол харилцаанд орж байдаг бөгөөд харилцан бие биедээ нөлөөлдөг гэж үздэг. Энэхүү онолын гол санаа нь зан үйл бол хувийн (өөрийн сэтгэл санаа, хариу үйлдэл г.м) ба орчны нөлөө (нөлөө бүхий хүмүүсийн бодол санаа, зөвлөгөө г.м) гэсэн хоёр талт хүчин зүйлийн үр дүн гэж үздэг. Энэ онол нь хувь хүний өөрийн туршлага, бусдын ажиглалт ба тэдний үйлдлийн үр дүнд голлон анхаардаг. Энэ онол хүмүүсийн хоорондын зан үйлд чиглэсэн хөтөлбөрийг боловсруулахад чиглэл болох 4 ухагдахууныг гаргаж ирсэн.

-Хоёр талт тодорхойлогч хүчин зүйлс- зан үйлийн өөрчлөлт нь хүн болон орчин нөхцлийн хоорондын хоёр чиглэлт харилцааны үр дүн юм.

-Зан үйлийн чадавх- зан үйлд нөлөөлөх мэдлэг, чадвар

-Хүлээж буй үр дүн- тодорхой зан үйлийг хэрэгжүүлбэл хүссэн үр дүндээ хүрнэ гэсэн итгэл

-Өөртөө итгэх итгэл- тухайн зан үйлийг амжилттай хэрэгжүүлэхэд шаардлагатай чадвар өөрт нь байгаа гэдэгт итгэх итгэл. Өөртөө итгэвэл түүнийгээ хийж, хэвшүүлэх магадлал өндөр байдаг гэж үздэг.

Ажиглалт болон бусдын үр дүнтэй үлгэр дуурайлал нь шинэ зан үйлийг эзэмшихэд чухал үүрэгтэй юм. Үлгэр дуурайлал болсон хүн нь тухайн зорилтот бүлгийн хүмүүстэй хэдийчинээ адил байна, түүнийг дуурайх

магадлал, хүсэл эрмэлзэл төдийчинээ илүү байдаг.

Оролдож хийж үзэж, туршиж, алдаж онох нь суралцах хамгийн үр дүнтэй арга зам юм. Тухайн зүйлийг хийх ур чадвар мөн чухал үүрэгтэй бөгөөд хэдийчинээ их оролдоно, чадвар нь төдийчинээ сайжирч уг үйлдлийг хэрэгжүүлэх хүсэл эрмэлзэл нь ч улам нэмэгддэг.

Нийгмийн танин мэдэхүйн онол

Энэ нь Нийгмийн суралцахуйн онолоос үүдэлтэй бөгөөд зан үйлийн өөрчлөлтийн хамгийн тохиромжтой онол байж болох юм. Энэ нь хүний сэдэл үйлдэл сайн сайхан байдлын төлөөх олон талтай учир шалтгаант бүтэц бүрэлдэхүүнээр тодорхойлогдох ба дэглэм сахилтын урьдач нөхцөл болон түүнийг дэмжих асуудлыг аль алиныг нь багтаадаг.²⁴

Энэхүү онолоор зан үйлийн өөрчлөлтийн үндсэн зарим нь хувь хүн болон гадаад орчин хоёрын хоорондын динамик харилцаа гэж үздэг. Нийгмийн танин мэдэхүйн онол эрүүл мэндийн эрсдлийн талаар мэдсэнээр өөрчлөлтөнд бэлэн болж түүнд өөрөө нөлөөлөх нь чухал хэмээн үздэг. Нөлөөтэй байгаа нь харагдаж байгаа түүний үр ашгийн талаарх итгэл үнэмшилтэй байх нь өөрчлөлтийн гол үүргийг гүйцэтгэнэ. Эрүүл

мэндийн зан үйлд материаллаг үр ашиг, зарцуулалт, зан үйлийн эерэг сөрөг хүлээгдсэн үр дүнгүүдийн нөлөөлөл чухал байдаг. Гарсан үр дүн нь хийж буй үйлдлийн нийгмийн сайшаал, зэмлэлээр илэрхийлэгдэж болно. Энэхүү онол нь гадны саад бэрхшээл, гарч болох харилцан адилгүй үр дүнг хянаж чадна гэдгээ ухамсарлаж зан үйлээ хянаж чадна гэсэн бүрэн итгэлтэй үед өөрчлөлтөд хүрэх боломжгүй гэж үздэг. Ихэнх архинд донтсон хүмүүс зан үйлээ өөрчилж чадахгүй байдаг нь гарч болох саад бэрхшээлийг тооцоогүй, зан үйлээ хянаж чадна гэсэн итгэл үнэмшил бүрэлдээгүйтэй холбоотой байна.

Өөрийгөө удирдах онол

Өөрийгөө удирдах онол нь өвчтөнийг тухайн аюул заналд дасан зохицохын хор уршиг, хувийн субъектив дадлыг эргэн харж түүнд анхаарлаа төвлөрүүлэх замаар дэглэм сахих үйл явцыг хийх хэрэгтэй гэж үздэг.⁸

СУДАЛГААНЫ ХЭСЭГ

“Өлзийт-Асар” ТББ-аар²⁵ үйлчлүүлж байгаа архины хамааралтай, гэр оронгүй, тэнэмэл амьдралтай 15 иргэнээс нөхцөл байдлын үнэлгээ авахдаа Австралийн эрдэмтэн Рожер Ван Дер Вийний нөхцөл байдлын үнэлгээний загварыг ашиглалаа. Энэхүү нөхцөл байдлын үнэлгээ нь

²⁴ ХДХВ/ДОХ салбар хоорондын асуудал болох нь., УБ 2010

²⁵ “Өлзийт асар” ТББ нь архины хамааралтай, гэр оронгүй, тэнэмэл

амьдралаар амьдардаг иргэдэд нийгмийн ажлын тусламж үйлчилгээ үзүүлдэг байгууллага юм.

гол асуудал ба хямрал, сэтгэц нийгмийн хүрээний үндсэн мэдээллийг олж авахад чиглэдэг учраас архины хамааралтай, гэр оронгүй, тэнэмэл амьдралтай иргэний талаарх урьд өмнө хийгдэж байгаагүй өргөн хүрээний мэдээллийг багтаасан.

Үндсэн мэдээлэл

Архины хамааралтай, гэр оронгүй, тэнэмэл амьдралтай иргэдийн дундаж нас 47,6 бөгөөд бүгд эрэгтэй хүн байна. Архины хамааралтай, гэр оронгүй болсон иргэд бүгд гэрлэсэн байсан бөгөөд одоогоор 100% гэр бүлээсээ салсан байна. Боловсролын байдлын хувьд дээд - 20%, бүрэн дунд - 53,3%, бүрэн бус дунд - 20%, бага боловсролтой - 6,6% байна. Эндээс дүгнэж үзвэл архинд донтоход боловсролын байдал төдийлөн нөлөөлдөггүй ажээ. Тэд багш, физик компьютерийн технологич, ерөнхий цэргийн командлагч, засал чимэглэлчин, токарьчин, өрлөгчин, жолооч, арьс ширний технологич, цахилгаанчин, мужаан, автокранчин, арматурчин зэрэг мэргэжилтэй бөгөөд огт мэргэжил эзэмшээгүй 2 хүн байна.

Зураг 1. "Өлзийт асар" ТББ-д сургалт хийж байна



Судлаачийн боловсруулснаар

Зураг 2. Гэр оронгүй хүмүүст халуун хоолоор үйлчилж байна



Судлаачийн боловсруулснаар

Зураг 3. Тэдгээр хүмүүсийн үсийг засч өгч байна



Судлаачийн боловсруулснаар

Зураг 4. Тэдгээр хүмүүсийн шархыг боож өгч байна



Судлаачийн боловсруулснаар

Гол асуудлууд ба хямрал

Архины хамааралтай, гэр оронгүй, тэнэмэл амьдралтай иргэдийн 40 хувь нь 13-15 настайгаасаа архи ууж эхэлсэн бөгөөд тэд ухамсарт амьдралынхаа ихэнх цаг хугацааг архи ууж өнгөрүүлжээ.

Ямар шалтгаанаар "Өлзийт-Асар" ТББ-д хандах болсон бэ? гэсэн асуултад архинаас гарахын тулд 86,6 хувь, сүрьеэгээ эмчлүүлэх гэж 66,6 хувь, нийгэмшихийн тулд 26,6 хувь, очих орон гэргүйн улмаас 26,6 хувь, өөрийгөө ялахын тулд 6,6 хувь, алсын хараагаа тодорхойлохын тулд 6,6 хувь, үр

хүүхэдтэйгээ харилцаагаа сайжруулахын тулд 6,6 хувь хэмээн хариулжээ.

Судалгаанд оролцсон архины хамааралтай, гэр оронгүй, тэнэмэл амьдралтай иргэд дараах байгууллагуудаас 1 сараас 1 жилийн хугацаанд нийгмийн халамжийн тусламж үйлчилгээ авч байжээ.

Сэтгэц, нийгмийн хүрээний мэдээ, баримт

Сэтгэц, нийгмийн хүрээний мэдээ, баримтад архины хамааралтай, гэр оронгүй, тэнэмэл амьдралтай иргэний бага нас, боловсрол эзэмшсэн байдал, сурлагын амжилт, багш болон үе тэнгийнхэнтэйгээ харилцах харилцаа, гэр бүлийн харилцаа, хөдөлмөр эрхлэлт, эрүүл мэндийн байдал, танин мэдэхүйн үйл ажиллагаа, аюулгүй байдал, харилцаа холбоо дэмжлэг тусалцаа, давуу тал, нөөц боломж, шашин шүтлэг, ирээдүйн төлөвлөгөө зэрэг өргөн хүрээний мэдээллийг авдаг.

ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Архины хамааралтай, гэр оронгүй, тэнэмэл амьдралтай иргэд сүүлийн үед эрс олширч байгаатай холбогдуулан тэдгээр хүмүүст сайхан сэтгэлээр тусалж, тэднийг хэвийн амьдралд нь буцаан оруулж, тэднийг нийгэмшүүлэх, тэдэнд амьдрах итгэл өгч, тэднийг ирээдүйд орон гэртэй, ажил төрөлтэй, нийгэмд эзлэх байр суурьтай хувь хүн болгон

төлөвшүүлэхэд “Өлзийт асар” ТББ болон Монгол улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн бус байгууллагууд багагүй хувь нэмэр оруулан ажиллаж байна.

Цаашид төр засаг маань дээрх хүмүүст анхаарлаа хандуулж гэр оронгүй архины хамааралтай гэх тодотголтой хүмүүс нийгэмд үгүй болж бүх хүмүүс элэг бүтэн, бүх иргэд нь ажилтай, орлоготой болох сайхан ирээдүй биднийг хүлээж байгаа байх гэж найдаж байна.

ДҮГНЭЛТ

“Өлзийт-Асар” ТББ-аар үйлчлүүлж байгаа архины хамааралтай, гэр оронгүй, тэнэмэл амьдралтай 15 иргэний дундаж нас 47,6 бөгөөд бүгд эрэгтэй хүн байгаа нь монгол улсын ид хөдөлмөрийн насны эрэгтэйчүүд архинд донтож байгааг харуулж байна. Хүн архи уугаад олон жил болдог бол тэнэмэл амьдралаар олон жил амьдардаггүй ажээ. Тэдний олонхид бие махбодь, сэтгэцийн өвчний шинж тэмдэгүүд илэрч байна. Архины хамааралтай, гэр оронгүй, тэнэмэл амьдралтай иргэдийн 86,6 хувь нь архинаас гарах бүхий л төрлийн эмчилгээг хийлгэж байсан боловч амжилт олоогүй өдийг хүрчээ. Тэдний гэр бүлийнхэн буюу эцэг эх, ах дүү, эхнэр архи уудаг байсан гэж 79,8 хувь нь хариулсан. Эндээс архины хамааралтай болж донтоход гэр бүлийнхэн, орчны нөлөө их байдаг нь харагдаж байна. Архинд донтоход айлын хэд дэх хүүхэд байх, эцэг эхтэйгээ хамт

бага насаа өнгөрүүлсэн эсэх, сурлагын амжилт, багш болон үеийнхэнтэйгээ харилцах харилцаа төдийлөн хамааралгүй байгааг судалгааны үр дүн харуулж байна. Судалгаанд оролцсон архины хамааралтай, гэр оронгүй, тэнэмэл амьдралтай иргэд бүгд гэрлэж байсан бөгөөд архи ууж эхэлснээс хойш бүгд салжээ. Энэ нь архичин хүнтэй хамт амьдрахад гэр бүлийнхэнд нь тэсвэрлэхийн аргагүй хүнд байдагтай холбоотой. Архины хамаарлаас гарсан эдгэрч байгаа иргэдийн 73,3 хувь нь Христ итгэлтэй байгаа нь бас нэг анхаарал татсан үзүүлэлт юм. Ер нь манайд архины хамааралтай, орон гэргүй, тэнэмэл амьдралтай иргэдэд Христийн шашны байгууллага, христ итгэлтэй хүмүүс чин сэтгэлээсээ тусалж дэмждэг тул тэд энэхүү шашныг шүтэх болсон байна. Тэд өөрийн давуу талыг бэрхшээлийн даван туулах чадвартай, итгэл даадаг, идэвх зүтгэлтэй, бие даах чадвартай,

даруу төлөв гэж дүгнэсэн. Мөн тэд архи уухгүй амьдрах, архинаас бүрмөсөн гарах, эрүүл саруул болох, ажилтай орлоготой болох, өөрийн гэсэн гэр оронтой болох, амар тайван амьдрах төлөвлөгөөтэй байгаа нь дахин нийгэмшиж нийгмийн идэвхтэй иргэн болохыг зорьж байгаа нь харагдаж байна.

НОМ ЗҮЙ

1. Гидденс.А., Социологи., УБ 2006
2. Жон Тэ Ги. Дотоод эдгэрэл., УБ 2012
3. МУ-ын Үндэсний статистикийн хороо, 2015
4. Монгол Улсын архидан согтуурахаас сэргийлэх, хяналт тавих үндэсний хөтөлбөр
5. Нейл МкКий нар Зан үйлийн төлөвшил ба хүмүүсийн оролцоо., УБ 2008
6. Нийгмийн халамжийн тухай хууль
7. ХДХВ/ДОХ салбар хоорондын асуудал болох нь., УБ 2010
8. Хорт зуршил ба нийгмийн ажлын үйлчилгээ, Нийгмийн ажлын зуны сургалт 2007
9. Смелзер.Н., Социологи., УБ 2001
10. Үндэсний статистикийн хороо, Дэлхийн банк “Ядуурлын дүр төрх-2016” судалгаа
11. Эрдэнэбаяр.Л., Архинд донтох өвчин., УБ 2009
12. Эрдэнэбаяр.Л., Донтох эмгэг судлал, УБ 2004